



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Налайх” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 196.6 (нэг зуун ерэн зургаан сая зургаан зуун мянган төгрөг) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлтээр 73.3 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн байх” тул дотоод хяналтыг сайжруулж, албан даалгаврын биелэлтийг ханган ажиллахыг “Налайх” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Баттулга)-д үүрэг болгосугай.

2.“Налайх” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Налайх” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

3.1.Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.6.3, 3.15, 3,8 болон Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2-т заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн Гүйцэтгэх захирал (Ц.Баттулга)-д хууль тогтоомжийн дагуу хариуцлагын арга хэмжээ авах;

3.2.Компанийн авлагын дансанд бүртгэлтэй байгаа, насжилт өндөр болон хугацаа хэтэрсэн 77.7 сая төгрөгийн найдваргүй авлагын асуудлыг судалж, авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллах;

3.3.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.4.Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” болон “Төрийн өмч эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.“Налайх” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Баттулга)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4.1.Төрийн өмчийн түрээсийн орлогын 40 хувь болох 19.9 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан улсын төсөвт төвлөрүүлэх;

4.2.Үлдэгдэл өртөгтэй боловч цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон 7 нэр төрлийн 47.3 сая төгрөгийн хөрөнгийг актлуулах асуудлыг хууль тогтоомжийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх;

4.3.Компанийн 2021 оны компанийн санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөөр бүртгэгдсэн 41 нэр төрлийн 71.05 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг залруулах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын дагуу эрх бүхий этгээд болон Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.4.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

4.5.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

4.6.Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно “ гэж заасныг дагуу мөрдөж ажиллах;

4.7.Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг гэрээ дүгнэсэн актыг үндэслэж төлдөг байх;


5.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд Төрийн өмчийн, удирдлага зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай.

6.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-г даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
28 дугаар тогтоолын хавсралт



“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн (мян.төгрөг)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ	Захирал Ц.Баттулга, Ерөнхий ня-бо Ц.Наранцэцэг	37,707.7	Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах,
2	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн хөрөнгө	Захирал Ц.Баттулга, Ерөнхий ня-бо Ц.Наранцэцэг	5,500.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалтыг мөрдөж ажиллах,
3	Гэрээ дүгнэсэн актгүй худалдан авалт	Захирал Ц.Баттулга, Ерөнхий ня-бо Ц.Наранцэцэг	105,578.7	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах,
4	“Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г зөрчин ТУЗ-ын шийдвэр гаргуулалгүй авсан зээл	Захирал Ц.Баттулга, Ерөнхий ня-бо Ц.Наранцэцэг	27,950.0	ТУЗ болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г мөрдөж ажиллах,
5	Үр ашиггүй хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс хүлээсэн алдагдал	Захирал Ц.Баттулга, Ерөнхий ня-бо Ц.Наранцэцэг	46,400.0	Төсвийн хууль, “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” мөрдөж ажиллах
6	Төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	Захирал Ц.Баттулга, Ерөнхий ня-бо Ц.Наранцэцэг	19,905.2	ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах,
	Дүн		196,641.6	(нэг зуун ерэн зургаан сая зургаан зуун дөчин нэгэн мянга зургаан зуу)